



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 0/62

Улаанбаатар хот

Батлан хамгаалахын стратеги
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө /2021-2024/-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга хурандаа Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хошууч генерал Д.Ганзориг, төрлийн цэргийн командлагч, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/ нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т хариуцуулсугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
9 дугаар сарын 9-ны өдрийн
16 дугаар тушаалын хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/2021-2024/

УЛААНБААТАР
2021 он



АГУУЛГА

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хоёр. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Гурав. БАТЛАН ХАМГААЛАХЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ, АЛСЫН
ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

Дөрөв. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Тав. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зургаа. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА АГЕНТЛАГ, ТӨРЛИЙН ЦЭРГИЙН
КОМАНДЛАЛ, НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН
УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

Долоо. ХАВСРАЛТ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Улс үндэстний хөгжлийн гадаад нөхцөл байдал нь дэлхий, бус нутгийн геополитик, аюулгүй байдлын орчин, хөрш орнуудын газар нутаг, хүн ам, улс төр, эдийн засаг, нийгмийн онцлог, хөгжлийн чиг хандлага, өөрчлөлтөөс шалтгаалдаг бол дотоод орчин нөхцөл нь тухайн улсын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөөс ихээхэн хамаардаг.

Дэлхий дахинд олон улсыг хамарсан зөрчил хямрал байсаар байгаа бөгөөд аливаа улсын аюулгүй байдал нь хөрш орнууд, бус нутгийн аюулгүй байдлын орчин, түүнд нөлөөлөгч хүчин зүйлүүдээр хязгаарлагдахаа болж дэлхийн аюулгүй байдлаас хамааралтай болсоор байна. Мөн улс, үндэстний аюулгүй байдлын талаарх уламжлалт ойлголтод цэрэг дайны аюулыг голлон авч үздэг байсан бол орчин үеийн олон улсын харилцаанд даяаршил, шинэчлэлийн үйл явц эрчимтэй өрнөхийн зэрэгцээ аюул, заналын талаарх ойлголт ч хувьсан өөрчлөгдөж, урьд өмнө байгаагүй шинэ төрлийн аюулгүй байдлын шийдлийн шинэ арга хэлбэрийг шаардах болсон.

Сүүлийн жилүүдэд улс бус субъект, бүлэглэлүүдийн зүгээс хийж буй гэмт үйлдлүүд жилээс жилд нэмэгдэж байгаагийн зэрэгцээ дэлхийн их гүрнүүд нэг нь нөгөөгийнхөө эсрэг эдийн засаг, дипломатын хориг арга хэмжээ авч, өөрийн нөлөө, хүрээгээ тэлэхийг эрмэлзэх боллоо.

Сөргөлдөгч талуудын зөрчилдөөн орчин үеийн техник, технологид суурилсан шинэ арга хэрэгслийг ашиглах болж, хил хязгааргүй кибер орон зайд ашиг сонирхлоо хамгаалах, мөн давамгай байдал олох сонирхол эрс ихсэж, эдийн засаг, нийгмийн бодит үйл ажиллагаатай холбож, оршин буй газар орон, цаг хугацаанаас хамаарахгүйгээр мэдээллийн дэд бүтцийг бүрэн хянах, удирдах, мэдээллийг тэмцлийнхээ гол объект болгох зорилгыг агуулах болсон байна.

Манай улсын оршин буй Ази, Номхон далайн бус нутаг нь цэрэг, зэвсгийн хүч ихээр төвлөрсөн, улс төр, үзэл суртлын эрс ялгаатай улс, гүрнүүдтэй, цөмийн зэвсгийн аюулаас гадна олон улсын терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг, салан тусгаарлах, хэт даврах үзэл, хүний эрх, хүмүүнлэгийн хямрал зэрэг уламжлалт бус аюул оршсоор байгаа нь манай улсын аюулгүй байдлын гадаад орчин тогтвортой биш байгааг илэрхийлж байна.

Монгол Улс геополитикийн орчин, хөрш улс, газар нутаг, хүн ам, улс төр, эдийн засаг, нийгмийн онцлогтойгоо уялдуулан аюулгүй байдлаа хангаж ирсэн. Манай улс хөрш хоёр оронтойгоо адил тэгш найрсаг харилцаатай хэдий ч тэдгээр улсын гадаадад нөлөөгөө тэлэх бодлого, дотоодын улс төр, үзэл суртлын хямралаас үүдэн үүсэж болзошгүй нийгмийн тогтвортгүй байдал, салан тусгаарлах үзэл, терроризм зэргээс үүдэлтэй аюул, занал манай улсын аюулгүй байдлын орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Улс орны аюулгүй байдлын гол зангилаа асуудал нь батлан хамгаалах бодлого, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоогоор дамжин шийдвэрлэгдэж байдаг. Батлан хамгаалах бодлого бол аливаа улсын төрийн бодлогын нэг онцгой төрөл бөгөөд үндэсний аюулгүй байдлаа хангах хүрээнд улс орноо аливаа халдлагаас хамгаалах, түүний бэлтгэлийг хангах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон төрийн бодлого юм.

Батлан хамгаалах бодлогыг тодорхойлох, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, Зэвсэгт хүний байгуулалтыг төгөлдөржүүлэх талаар төр, засгийн зүгээс анхаарал хандуулж ирсэн.

Тухайлбал, батлан хамгаалахын эрх зүйн хоёр дахь шинэчлэлийг 2015 оноос эхлүүлж, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, батлан хамгаалахын багц хууль, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

“Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” баримт бичигт “Цэргийн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг байгуулах” гэсэн томоохон зорилгыг дэвшүүлсэн нь алсын хараа, зорилго, зорилт, хүрэх түвшинг тодорхойлсон стратегийн төлөвлөлтийн баримт бичиг болсон юм.

Дээрх стратегийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнүүдэд холбогдох зорилт, арга хэмжээнүүдийг тусган хэрэгжилтийг нь хангаж ирсэн.

Бодлогын баримт бичгүүдэд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг сүүлийн гурван жилийн байдлаар авч үзвэл дараах байдалтай байна:

Бодлогын баримт бичгийн нэр	Хэрэгжилт, хувиар		
	2018 он	2019 он	2020 он
Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс	84,1	83,4	85,0
Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030	80,0	83,2	85,0
Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	89,2	97,0	98,5
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	92,0	94,0	92,5
Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр	47,5	58,2	85,0

Бодлогын баримт бичгүүдэд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

- Батлан хамгаалахын эрх зүйн орчин боловсронгуй болж, төрийн цэргийн байгууллын тогтолцоо тодорхойлогдож, Монгол Улсын иргэн хуулиар хүлээсэн цэргийн алба хаах үүргээ биелүүлэх хэлбэр өргөжиж, цэргийн алба хаагчийн эрх зүйн баталгаа дээшилсэн;

- Зэвсэгт хүчний бүтцэд шинэ төрлийн цэргүүд шинээр байгуулагдаж, цэргийн нэгтгэл, анги, салбарын бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг нэмэгдүүлсэн;

- Зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлого, цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоо шинэчлэгдсэн;

- Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайд хяналт тавих, агаарын болзошгүй халдлагаас хамгаалах боломж тодорхой түвшинд нэмэгдсэн;

- Цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилсэн.

- Улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд цэргийн алба хаагчдыг оролцуулснаар зарим томоохон төслүүд болино хугацаанд чанарын өндөр түвшинд хэрэгжсэн.

Мөн батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй өргөжүүлж, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудаас авах буцалтгүй тусlamжийг нэмэгдүүлсэн.

Хэдий тийм боловч батлан хамгаалах үйл ажиллагааны төсөв хязгаарлагдмал, улсын төсвийн хөрөнгө оруулалт бага байгаа нь төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл байлаа. Тухайлбал, Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, шинэчлэн сайжруулах, нөөц бүрдүүлэх, сольж шинэчлэх, шинээр цэргийн анги байгуулах зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ихээхэн төсөв, хөрөнгө шаардлагатай байдгаас хэрэгжээгүй байна.

Ийнхүү аюулгүй байдлын орчны өөрчлөлт, төрөөс батлан хамгаалах талаар дэвшүүлсэн бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах талаар туссан зорилтыг хэрэгжүүлэх, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, улс орныг батлан хамгаалах бэлтгэлийг хангах асуудал нь 2021-2024 оны стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлагыг бий болгосон.

Тус хэрэгцээ шаардлагыг хангах, бодлогын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “*Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө /2021-2024 он/*”-г Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалыг баримтлан боловсрууллаа.

Хоёр. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Батлан хамгаалахын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		60
Үүнээс	Батлан хамгаалахын хуулийн тоо	30
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	30
Ерөнхий чиг үүрэг: Батлан хамгаалах		
Үндсэн чиг үүрэг ҮЧҮ-1: Улсыг батлан хамгаалах бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
	Батлан хамгаалахын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	УИХ, ЗГ, ХЗДХЯ, ЗХЖШ, ТЦК-ууд
	Улсыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх	УИХ, УАБЗ, Ерөнхийлөгч, ЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Батлан хамгаалах бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, ЗХЖШ
	Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, зохион байгуулах	ЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгох	УИХ, ЗГ, ЗХЖШ
	Иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх	ЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах	УИХ, ЗГ, ГХЯ, ЗХЖШ
	Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх	УИХ, ЗГ, СЯ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	ЗГ, ЗХЖШ, БХЭШХ
	Батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	ЗХЖШ, БХЭШХ
	Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийг	ЗХЖШ, БХЭШХ

	шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх	
	Цэргийн зориулалттай зэвсэг, сум, галт хэрэглэл үйлдвэрлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	ЗГ, ЗХЖШ, БХЭШХ
	Цэргийн зориулалттай химиин хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах	ЗГ, ГХЯ, ЗХЖШ
	Аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах талаар баримтлах бодлогыг тодорхойлох	ЗХЖШ, БХЭШХ
	Батлан хамгаалах нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	УИХ, ЗГ, ЗХЖШ, ТЦК
	Улсын эдийн засаг, нийгэм, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэн зохион байгуулах	УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, аймаг, нийслэл-ийн ЗДТГ, ЗХЖШ, ТЦК
	Иргэний эрүүл мэндийг хамгаалах, иргэнд эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	ЗГ, БШУЯ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх	УИХ, ЗГ, Ерөнхий хянан шалгач
	Цэргийн алба хаагч, түүний гэр бүл, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагчийн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх	ЗГ, ХНХЯ, СЯ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, байгууллагууд
	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн талаарх харилцааг боловсронгуй болгох бодлого боловсруулах	УИХ, ЗГ, СЯ, ХНХЯ, ЗХЖШ
	Батлан хамгаалах материалыг нөөцийн хэмжээ, байршлыг тогтоох, түүнийг бүрдүүлэх	УИХ, ЗГ, ЗХЖШ
	Батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх	УИХ, ЗГ, аймаг, нийслэл-ийн ЗДТГ, ЗХЖШ, ТЦК
	Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний цэргийн боловсрол, соёл, урлаг, спорт, эрүүл мэндийн байгууллагыг бодлогын удирдамжаар хангах үйл ажиллагаанд хяналт тавих	ЗХЖШ, Ерөнхий хянан шалгач
	Батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчтэй хуулийн этгээдийн удирдлага зохицуулалт	ТӨХ, ЗХЖШ
ҮЧҮ-2: Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх	Орон нутгийн хамгаалалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх	ЗГ, ТЗТБ, ЗХЖШ, ҮАБХТЧҮБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
	Орон нутгийн хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлэхэд аймаг,	ЗГ, ЗХЖШ

		нийслэлийн Засаг даргыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах	
		Улсын хэмжээнд орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, зохион байгуулах	ЗГ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
		Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг томилгоожуулах, үүрэг гүйцэтгүүлэхээр бэлтгэх	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
		Орон нутгийн хамгаалалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
		Орон нутгийн хамгаалалтын онц болон дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг зохион байгуулах	УИХ, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
		Орон нутгийн хамгаалалтын сургалтыг төлөвлөх, зохион байгуулах	ЗГ, ТЗТБ, НӨҮБ, аймаг, нийслэлийн ЗД, ЗХЖШ
		Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийг зохион байгуулах	ЗГ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
		Аймаг, нийслэлийн Засаг даргын цугларалтыг зохион байгуулах	ЗГ, аймаг, нийслэлийн ЗД
		Орон нутгийн хамгаалалтын онол, арга зүй, шинжлэх ухаан, инновацийн хөгжлийг хангах	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ, БХЭШХ
		Орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх, даалгаваржуулах	УИХ, ЗГ, ТЗТБ, НӨҮБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
		Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт гаргах	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
ҮЧҮ-3: Нэгдсэн төлөвлөлт дайчилгааны бэхжүүлэх	удирдлага, бүхий тогтолцоог	Улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
		Улс орныг ерөнхий төлөвлөгөөний дагуу дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг хангах	УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
		Дайчилгааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах бэлтгэлийг хангах	ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэлийн ЗД, ЗХЖШ
		Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих	ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ
		Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөний төслийг хянаж, дүгнэлт гаргах	ЗГ, ТЗТБ аймаг, нийслэлийн ЗД
		Улсын болон цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх журам,	ЗГ, ЗХЖШ

	тэдгээрийн хэмжээ, байршлыг тогтоох	
	Дайчилгааны бэлтгэлийг хангах, нөөцийг бүрдүүлэх, нэгдсэн тооцоог хөтлөх	УИХ, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийг дайчлах журмыг тогтоож, хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах	ЗГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЗХЖШ
	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт, цугларалтыг зохион байгуулах	ЗГ, ТЗТБ, ЗХЖШ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
	Төрийн удирдах албан тушаалтны сургалт, цугларалтыг зохион байгуулах	ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ЗХЖШ
	Дайчилгаатай сургууль явуулах журам хугацаа, түүнд оролцуулах дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг тогтоох	ЗГ, ТЗТБ, ЗХЖШ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД
	Улсын дайчилгааны бэлтгэлийг хангахтай холбогдсон үндсэн арга хэмжээг зохион байгуулах	ЗГ, ТЗТБ, ЗХЖШ, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны ЗД
	Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагыг дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд шилжүүлэх бэлтгэлийг хангах	ЗГ, ТЗТБ, НЗБ, ЗХЖШ
	Дайны байдлын үед үйлчлэлийг зогсоох, хязгаарлах хууль тогтоомжийн нэр, заалтыг тодорхойлох	УИХ, ЗГ, ЗХЖШ
	Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх бэлтгэлийг хангах	ЗГ, ЗХЖШ
	Баталгаат албан тушаалын жагсаалтыг гаргах	ЗГ, ЗХЖШ
	Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд нөхөх олговрыг тогтоох	ЗГ, ЗХЖШ
	Дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэргэжлийн удирдлагаар хангах	Ерөнхийлөгч, ЗГ, ТЗТБ, аймаг, нийслэлийн ЗД
	Дайчилгааны явцын талаарх нэгдсэн мэдээ гаргаж, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тайлагнах	УИХ, ЗГ, УАБЗ, ТЗТБ, аймаг, нийслэлийн ЗД, ЗХЖШ
	Дайчилгааны явцыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны	ЗГ, ЗХЖШ, Ерөнхий хянан шалгагч

	байгууллага, байгууллага, аж ахуйн нэгжид шалгаж туслах	
ҮЧҮ-4: Мэргэжлийн суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх	Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах	ЗГ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Зэвсэгт хүчний сургалт, бэлтгэл, цэргийн бүх шатны удирдлагын байгууллагуудын бэлэн байдлыг хангах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Олон улсын болон бус нутгийн цэрэг, улс төрийн байдал, үүсч болзошгүй цэргийн аюул заналыг судлах	ЗХЖШ, ТЦК
	Зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих	Ерөнхийлөгч, ЗХЖШ, ТЦК
	Зэвсэгт хүчнийг хэрэглэх ерөнхий болон стратегийн дэлгэн байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	Ерөнхийлөгч, ЗХЖШ, ТЦК
	Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Цэргийн дайчилгааны даалгаврыг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	ЗХЖШ, ТЦК
	Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Төрийн цэргийн номлолыг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Ерөнхийлөгч, ЗХЖШ, ТЦК
	Төрийн цэргийн байгууллын харилцан ажиллагааны журмыг тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах	ЗГ, ЗХЖШ, ТЦК
	Нутаг дэвсгэрийн төхөөрөмжлөл, цэргийн дэд бүтцийг бэхжүүлэх	ЗГ, ТЗТБ, ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги,

		салбар, байгууллагууд
	Цэргийн удирдлага, мэдээллийн хэрэгслийн шинэчлэлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Цэргийн боловсрол, сургалт бэлтгэлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Зэвсэгт хүчний бүх нийтийн буюу хэсэгчилсэн дайчилгаагаар өргөтгэн зохион байгуулах бэлтгэлийг хангах	ЗХЖШ, ТЦК, НЗБ, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Зэвсэгт хүчний хэрэгцээт зэвсэглэл, цэргийн техникийн төрөл, тоог тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах	ЗГ, ЗХЖШ, ТЦК
	Цэргийн болон нэгдсэн ажиллагааны нөөцийн хэмжээ, цувраажилтыг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК
	Цэргийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Цэргийн байгууллагуудын харилцан ажиллах журам тогтоох, нэгдсэн ажиллагааны төлөвлөгөөг батлах	ЗХЖШ, ТЦК
	Цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, нэгтгэл, анги
	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох	ГХЯ, ЗХЖШ, ТЦК, ТЦБ, нэгтгэл, анги, салбар, байгууллагууд
	Агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах	ЗХЖШ, АЦК, анги, салбар
	Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх журам тогтоож, биелэлтийг хянах	ЗХЖШ, АЦК
	Цэргийн мэдээлэл, дүн шинжилгээ, орон зайн тандалт судалгаа явуулах	ЗХЖШ, ТЦК, анги, салбар
	Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох	ЗХЖШ, ТХЦК
	Улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар
	Аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам,	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар

	эд юмсыг аврах, хор уршгийг арилгах	
	Гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусlamжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар
	Цэргийн зориулалттай тэсэрч дэлбэрэх зүйлийг аюулгүй болгох	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги
	Зэвсэгт хүчний хэмжээнд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах	ЗХЖШ, ТЦК, нэгтгэл, анги, салбар, байгууллага

Гурав. БАТЛАН ХАМГААЛАХЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ, АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ:

Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтод нийцсэн улс орноо батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

АЛСЫН ХАРАА:

Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны төлөв, өөрчлөлтийн хандлагад нийцсэн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, улс орны хөгжлийн зорилго, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэн, улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтохуйн аюулгүй байдлыг найдвартай хангахад оршино.

Дөрөв. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээ стратегийн шийдвэр гаргахад удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, байгууллага нь бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг биелүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломж ямар байгааг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан дараах байдлаар тодорхойллоо.

4.1. Гадаад орчны шинжилгээ

Гадаад орчны шинжилгээг хийхдээ аюулгүй байдлын орчин, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөлөл, эерэг боломж, сөрөг нөлөөлөл, үүсч болох эрсдэлийг тодорхойллоо.

4.1.1. Аюулгүй байдлын орчинд хийсэн шинжилгээ / хөрш ОХУ, Хятад /

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС	
Давуу тал:	Сул тал:
<p>Монгол Улс Оросын Холбооны Улс (ОХУ)-тай батлан хамгаалах харилцааг бэхжүүлэн хөгжүүлснээр Монгол Улсын тусгаар тогтолц, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах нөхцөл боломж бүрдэж, баталгаа бий болно.</p> <p>- ОХУ нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн, цэргийн хүчин, шинжлэх ухаан, цэрэг-аж үйлдвэрээр тэргүүлдэг, дэлхийн нөлөө бүхий хүчирхэг том гүрэн бөгөөд тус улстай найрсаг харилцаатай байж батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлснээр Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэх, сайжруулах, зэвсэглэл, техникийн сэлбэг, галт хэрэглэл, түлш шатахууны хангарт авах, цэргийн мэргэжилтэн бэлтгэх таатай нөхцөл, боломж бүрдэнэ.</p> <p>- ОХУ-ын нутаг дэвсгэрийг давж гуравдагч улс, хүчинээс цэргийн аюул занал үүсэх нөхцөл боломж хязгаарлагдмал.</p> <p>- Монгол Улсад гадны халдлага, түрэмгийлэл учрах нь тодорхой болох үед тус улс, түүний тэргүүлсэн цэрэг-улс төрийн байгууллагатай холбоотон болж цэргийн болон цэрэг-техникийн тусламж дэмжлэг авснаар аюулгүй байдлаа хангах, хамгаалах бололцоотой.</p>	<p>- ОХУ-ын нөлөө, бүс нутгийн бодлогын хүрээнд автаж, эдийн засгийн хараат байдалд байна.</p> <p>- Монгол Улсаас гадаадад гаргах бүтээгдэхүүн ОХУ-ын нутгаар дамжин гарах учир тээвэрлэлт, татварын дарамт хөрш улсын зүгээс байнга учирна.</p> <p>- Монгол Улсын гадагшаа урсдаг ихэнх гол мөрнүүд (Хэрлэн голоос бусад) нь ОХУ-ын нутаг руу гардгаас тэдгээр гол мөрнийг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах боломжийг ОХУ-ын зүгээс олон улсын хуульд дулдуудан хязгаарладаг.</p> <p>- Гадаадын бусад улстай цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, цэргийн зориулалттай бүтээгдэхүүн гуравдагч улсаас авах боломжийт хязгаарладаг.</p> <p>- Цэргийн зориулалттай болон стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүнийг зөвхөн ОХУ-аас авч, зэвсэглэл техникийн засвар үйлчилгээ, сэлбэг, шатахуун, галт хэрэглэлийн хангарт, инженер техникийн ажилтны бэлтгэлийн хувьд тус улсаас хамааралтай байна.</p> <p>- Хөрш улсын эдийн засаг хүчирхэгжиж зарим үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүний хангарт, банк санхүүгийн ажиллагааг манай нутагт</p>

	явуулбал дотоодын тогтолцоог эвдэх, нөлөөндөө оруулах эрсдэлтэй.
Боломж:	<p>- эдийн засаг, санхүүгийн дэмжлэг, зээл, тусламж авах боломжтой.</p> <p>- Хоёр улс хөрш зэргэлдээ оршиж газар нутгийн хувьд ойр дөт, дэд бүтэц харьцангуй ахицтай хөгжиж байгаа нь тус улсаас хэрэгцээт бараа бүтээгдэхүүний хангалтыг түргэн шуурхай авах боломжтой.</p> <p>- Монгол Улс эдийн засгийн салбарууд, аж үйлдвэрээ хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх тохиолдолд ОХУ нь том зах зээл байх боломж бий.</p> <p>- Монгол Улс өөрийн бараа бүтээгдэхүүнээ ОХУ-ын нутгаар дамжуулан тэдний тээврээр гуравдагч улсад гаргах.</p>

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

Давуу тал:	Сул тал:
Монгол Улс, БНХАУ-ын батлан хамгаалахын харилцаа нь хоёр улсын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тус улсын удирдлага ч цэргийн харилцаа, хамтын ажиллагаа нь бусад салбарын хамтын ажиллагааны тулгийн чулуу хэмээн үздэг. Тиймээс БНХАУ-тай батлан хамгаалах салбарт харилцааг хөгжүүлснээр тусгаар тогтол, газар нутгийн бүрэн бүтэн байдал баталгаажих, цэргийн итгэлцэл, улс төрийн харилцан ойлголцол нэмэгдэх, цэргийн мэргэжилтэн бэлтгэх төдийгүй хэмжээ нь тасралтгүй нэмэгдэж байгаа цэргийн буцалтгүй тусламж нь Зэвсэгт хүчний шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд манай цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, улс орны бүтээн байгуулалтад чухал хувь нэмэр оруулах давуу талтай.	<p>- Тус улс манай улсын зүгээс АНУ-тай явуулж байгаа цэргийн хамтын ажиллагааны идэвхжилтэд эмзэг ханддаг.</p> <p>- манай улс нь эдийн засаг, худалдааны хувьд Хятадаас хэт хамааралтай байна.</p> <p>- гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хараат байна.</p> <p>- Хятадын эсрэг үзэл Монголд түгээмэл байна.</p> <p>- үндэсний ашиг сонирхлын зөрүүтэй байдал байна. Тухайлбал, Далай ламын асуудал.</p>

Боломж:	Аюул занал:
<p>- Хоёр талын зэвсэг техникийн хамтын ажиллагаа хөгжих эхлэл тавигдаж байгаа, үүнийг цаашид өргөжүүлэх боломж өндөр. Хятадын зэвсэглэлийн чанар улам сайжирч дэлхийн тэргүүлэх</p>	<p>- БНХАУ-ын зүгээс шууд учрах цэргийн аюул хязгаарлагдмал.</p> <p>- Цөмийн зэвсэг түрүүлж хэрэглэхгүй, “Над руу дайрахгүй бол, би хүн руу дайрахгүй”, идэвхтэй батлан</p>

<p>жишигт ойртож байгаа тул энэ чиглэлд боломжийг эрэлхийлэх нь боломж нэмэгдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Хилийн чанадад энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр хамтарч ажиллах боломжтой. - Терроризмын эсрэг хоёр талын хамтарсан хээрийн сургууль явуулах нь энэ чиглэлээр туршлага суралцах боломж бүрдэнэ. 	<p>хамгаалалт гэсэн цэргийн номполуудыг хэрэгжүүлж байгаа.</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улстай хил залгаа ШУӨЗО-ноос террорист халдлага үйлдэгдэх, хэрэв дотоодод нийтийг хамарсан гамшиг учирвал дүрвэгчид хил давж орж ирэх аюул занал үүсч болзошгүй. - БНХАУ-ын ХАЧА-ийн бие бүрэлдэхүүн, зэвсэглэл техникийн хувьд манай улсын Зэвсэгт хүчинээс хэд дахин давуу байдаг нь цэргийн аюул занал учруулах эрсдэлийг нэмэгдүүлдэг.
---	---

4.1.2. Аюулгүй байдлын орчинд хийсэн шинжилгээ / Гуравдагч хөрш АНУ, Япон, БНСУ /

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	
Давуу тал:	Сул тал:
<p>Тус улстай батлан хамгаалах салбарт хамтран ажилласнаар:</p> <ul style="list-style-type: none"> - Хоёр хөршийн цэрэг, улс төр, эдийн засгийн нөлөөг бууруулах; - Ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дэмжих; - Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогоо улс төр, дипломатын арга замаар хэрэгжүүлж Монгол Улсын аюулгүй байдлаа хангахад гурав дахь хөрш болон ОУ-ын байгууллагуудын дэмжлэг авахад АНУ дэмжих, нөлөөлөх; - Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлэх; - АНУ-ын дэлхийд тэргүүлэх цэрэг, стратегийн хувьд туршлага сургамж, боловсрол, төхникийн дэмжлэг авах; - Бүс нутгийн аюулгүй байдал хангах. 	<p>- Монгол Улс, АНУ-ын цэргийн хамтын ажиллагааны идэвхжилд Хятад, ОХУ нь эмзэг ханддаг тул хоёр хөршийн зүгээс манай улстай харилцах харилцаанд нөлөөлж болзошгүй;</p> <ul style="list-style-type: none"> - Газар зүйн байрлал алслагдсан, далайд гарцгүй, гуравдагч ороний хиллэдэггүй; - Цэрэг, техникийн тусlamж авах боломж хязгаарлагдмал; - Их гүрнүүдийн цэрэг, улс төр, эдийн засгийн нөлөө ирэх магадлал их; - Зэвсэглэл, техникийн зөрүүтэй байдал.
Боломж:	Аюул занал:
<p>Цаашид батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд уламжлалт хэлбэрийг хадгалахын зэрэгцээ шинэ чиглэлийг өргөжүүлэх гарцыг бий болгоно.</p> <ul style="list-style-type: none"> - Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт улс төр, дипломатын арга замаар хэрэгжүүлж, аюулгүй байдлаа бэхжүүлэх; - Батлан хамгаалах, харилцаа хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчиний төрлийн цэргийг хөгжүүлэх; 	<p>- Хятад, АНУ, ОХУ хоорондын өрсөлдөөн, нэг нэгнээ хазаарлах оролдлогууд нь худалдааны дайнаас халин аюулгүй байдлын нөлөөний бүсээ хуваах чиглэлд шилжвэл Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалд томоохон сорилт учруулах;</p> <ul style="list-style-type: none"> - Их гүрнүүдийн улс төр, эдийн засгийн дарамт ирэх; - Хөрш орнуудын дарамт, шахалт, нөлөө ихсэх магадлалтай.

- Мэргэжлийн Зэвсэгт хүчнийг чадавхжуулах, хөгжүүлэх;
- Орчин үеийн зэвсэглэл, тоног төхөөрөмж ашиглах;
- Бие бүрэлдэхүүний боловсролын түвшинг сайжруулах;
- Дэлхийн улс орнуудтай харилцааг нэмэгдүүлж, улс орны нэр хүнд ОУ-д өсөх боломжтой.

ЯПОН УЛС

Давуу тал:	Сул тал:
<p>Гуравдагч хөршийн бодлогоор дамжуулан Үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулах бодлоготой нийцнэ. Монгол, Японы стратегийн түншлэлийн харилцаанд батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа чухал хувь нэмэр оруулж, түлхэц үзүүлж байна. Япон Улстай батлан хамгаалах харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх нь цэргийн мэргэжилтэн бэлтгэхэд төдийгүй тус улсын БХЯ-наас “Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хурээнд хэрэгжүүлж байгаа цэргийн инженерийн сургалт, дадлага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний зам, барилгын салбаруудын чадавхыг нэмэгдүүлэхээс гадна Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх “Барилга инженерийн рот”-ын бэлтгэлийг хангах, тус ротын үндсэн мэргэжилтэн бэлтгэгдэх чухал ач холбогдолтой.</p>	<p>Манай улсын зүгээс Япон, АНУ зэрэг гуравдагч хөрштэй явуулж буй цэргийн хамтын ажиллагааны идэвхжилтэд Хятад эмзэг ханддаг. Тиймээс Хятадын зүгээс дарамт, шахалт, нөлөө ихсэх аюултай.</p> <p>Манай улсын зах зээл жижиг, далайд гарцгүй, хоёр их гүрнээс нэлээд хамааралтай байдаг боловч байгалийн баялгаар дэлхийн 10 том улсын нэг гэдэг. Энэ нь байгалийн баялаггүй Япон улсын хувьд урт хугацаанд нөөцөө баталгаажуулж авах бодлогын нэг субъект нь Монгол Улс байж болох юм.</p>
Боломж:	Аюул занал:
<p>Япон Улстай батлан хамгаалахын харилцаа, хамтын ажиллагааг хоёр улсын Засгийн газар, “Монгол Улсын БХЯ, Япон Улсын БХЯ хооронд батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-т үндэслэн дараах чиглэлээр гүнзгийрүүлэн хөгжүүлэх нөөц бололцоотой юм.</p> <ul style="list-style-type: none"> - НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр харилцан туршлага солилцох, цаашид НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд хамтран оролцох боломжийг нээх, - Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхыг дээшлүүлэх хөтөлбөрийг 	<p>Япон Улсын зүгээс шууд учрах цэргийн аюул байхгүй хэдий ч хөгжингүй улс орнуудын өрсөлдөөн, нэг нэгнээ хазаарлах оролдлогууд нь Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалд томоохон сорилт учруулж болзошгүй.</p>

цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, цаашид Зэвсэгт хүчний Агаарын цэргийн чадавхыг дээшлүүлэх чиглэлд өргөжүүлэх,

- Бус нутаг, олон улсын аюулгүй байдал, олон улсын терроризмын талаар мэдээлэл солилцох,
- Гамшгаас хамгаалах, хүмүүнлэгийн тусламж, чадавхыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах, туршлага, сургамжаас суралцах,
- Цэргийн судалгааны байгууллага хооронд хамтран ажиллах, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх боломжтой.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Давуу тал:	Сул тал:
<p>Монгол Улс, БНСУ-ын батлан хамгаалахын харилцаа нь харилцан айлчлал хийх, цэргийн бүх түвшний төлөөлөгч солилцох, БХЯ-д хоорондын зөвлөлдөх уулзалт хийх, цэргийн мэргэжилтэн харилцан сургаж бэлтгэх, хамтарсан сургалт дадлага явуулах, олон улсын хурал, семинар, үзэсгэлэн арга хэмжээнд харилцан урьж оролцуулах зэрэг чиглэлээр идэвхжин хөгжик байна. Үүнээс гадна хоёр улсын харилцааны байдлыг авч үзэхэд гадаад харилцааны хувьд чөлөөтэй, олон улстай найрсаг хамтын ажиллагаатай. Гадаад улсуудын аюул занал байхгүй харьцангуй тайван улсуудын тоонд зүй ёсоор багтдаг. Өөрөөр хэлбэл терроризм, дүрвэгсдийн асуудал, хүний наймаа, хар тамхи, үндэстэн дамнасан мөнгө угаалт зэрэг уламжлалт бус аюул заналаас нэлээд сэргийлж чадсан. Түүнчлэн иргэний дайн, шашин хоорондын мөргөлдөөн, салан тусгаарлалт, улс төрийн олон төрлийн бослого зэрэг нь Монгол Улсад юм. Өмнөд болон Хойд Солонгостой адил тэгш найрсаг харилцаатай.</p>	<ul style="list-style-type: none"> - эдийн засгийн хувьд манай хүн ам цөөн тул зах зээл жижиг; - ОХУ, БНХАУ-ын хамаарал ихтэй. Монгол Улсын байгалийн баялаг, БНСУ-ын менежмент, технологи, хөрөнгө оруулалт зэргийг нэгтгэн хамтран ажиллаж чадахгүй байна. - Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч нефть болон бусад ашигт малтмалын үнэ унаснаар нэг талдаа ихэнх түүхий эдээ гаднаас авдаг БНСУ-ын худалдааны тэнцэлд ашигтай байна.
Боломж:	Аюул занал:
<p>-Талууд уламжлалт хамтын ажиллагааны хэлбэрийг хадгалах энэ хүрээнд Монгол Улсын цэргийн алба хаагчдыг БНСУ-ын цэргийн их, дээд сургуульд болон богино хугацааны сургалтад үргэлжлүүлэн суралцуулах,</p>	<p>Солонгосын хойгт цөмийн зэвсгийн аюул оршин байгаа, тус бус нутагт бий болсон нөхцөл байдлыг хүчээр, яаран өөрчлөх гэсэн оролдлого нь асуудлыг улам хурцатгах төдийгүй, бус нутгийг бүхэлд нь хамарсан зэвсэгт</p>

хамтарсан хээрийн сургуулийг тогтмолжуулах, цэргийн эмнэлгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар ажиллах боломжтой. Энэ нь хоёр улсын цэргийн алба хаагчид харилцан суралцах, туршлага солилцох, харилцан ойлголцлыг улам нэмэгдүүлэхэд ач холбогдолтой;

- Монгол Улс, БНСУ-ын худалдааны харилцаа нь хоёр хөршийн эдийн засгийн нөлөөг саармагжуулах, нэг улсаас хараат байдлыг багасгах, гадаад худалдааны олон эх үүсвэртэй болох, бус нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн орох, олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зэрэг арга замаар дотоод эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, улсын төсөв, ажлын байр нэмэгдүүлэх;
- харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэж ахиулах;
- талууд улс төрийн итгэмжилсэн харилцааг бэхжүүлэх, хоёр улсын стратегийн яриа хэлэлцээний механизмыг бий болгож, тогтмолжуулах;
- хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Монгол Улс, БНСУ-ын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах;
- БНСУ-ын Хөгжлийн албан ёсны тусlamжийн үр өгөөжийг дээшлүүлэх, буцалтгүй тусlamж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- олон талт, бус нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний сүлжээ, Зүүн Азийн Төмөр замын хамтын нийгэмлэг байгуулах зэрэг бус нутгийн санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;
- Солонгосын хойг, Зүүн хойд Азийн бус нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хамтын ажиллагааг идэвхжүүлэх зэрэг боломж байна.

мөргөлдөөнд хүргэх аюултай. Энэ нь манай улсад Умард Солонгосоос дүрвэгчид орж ирэх магадлалыг нэмэгдүүлнэ.

Тус бус нутагт их гүрнүүдийн нөлөөний хүрээний төлөөх өрсөлдөөн байгаа нь манай улсын гадаад бодлого, аюулгүй байдалд сорилт учруулна.

4.1.3. Дэлхийн болон бус нутгийн хамтын нийгэмлэгийн байгууллагуудад хийсэн шинжилгээ /НҮБ, НАТО/

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА	
Давуу тал:	Сул тал:
<p>Манай Зэвсэгт хүчин анх 2002 онд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлснээс хойш 18 жилийн хугацаанд дэлхийн 3 тивд явагдсан НҮБ-ын 11 энхийг сахиулах ажиллагаа болон НАТО-гийн цэргийн ажиллагаанд 17000 гаруй цэргийн алба хаагчийг оролцуулж байна. Монгол Улсын батлан хамгаалах бодлогод НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын цэргийн ажиллагаанд өөрийн хувь нэмрийг оруулах явдал чухал байр суурь эзэлдэг. Энэ нь өөрийн аюулгүй байдлыг хангах, олон улсын түвшинд Монгол Улсын байр суурийг бэхжүүлэх, өөрийн Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийхэд чухал ач холбогдолтой.</p>	<p>НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд дахь оролцоогоо нэмэгдүүлэх боломжтой байдлаар хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн хувьд хязгаарлагдмал боломжтой байгаа зэрэгэс болж хүндрэл учирч байна.</p>
Боломж:	Аюул занал:
<p>Монгол Улсын Зэвсэгт хүчин тусгай хүчний рот, барилга инженерийн рот, цэргийн эмнэлгийн салбарыг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах боломжтой.</p> <p>Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаан дахь оролцоогоо нэмэгдүүлэх боломжтой бөгөөд ЦАХ-дын үндсэн үүргээ гүйцэтгэх ур чадвар нэмэгдэх, олон улсын түвшинд цэргийн ажиллагаанд оролцох туршилага хуримтлуулах боломжийг үүсгэдэг.</p>	<p>НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийн бие бүрэлдэхүүн аюулгүй байдлын эрсдэлийн өндөр түвшинд үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цагийн байдлын хувьд тухайн улс орны улс төрийн тогтвортгүй байдал, зэвсэгт бүлэглэлүүдийн хоорондох мөргөлдөөн идэвхжих үед аюулгүй байдал хурцдаж, халдлага дайралтад өртөх магадлал ихэсдэг нь бие бүрэлдэхүүний амь насанд аюул учруулах магадлалыг өндөрсгедөг.</p>
УМАРД АТЛАНТЫН ГЭРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА /НАТО/	
Давуу тал:	Сул тал:
<p>НАТО-гийн Умард Атлантын Зөвлөл 2012 оны 3 дугаар сарын 19-ний өдөр ээлжит хуралдаанаараа “Монгол Улс, НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг баталснаар хоёр талын хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс бүрдэж, “түнш орон”-ны статустай болсон. Ингэснээр дараах давуу талууд бий болсон.</p>	<p>Крымын хямралын улмаас ОХУ Европ, АНУ, НАТО-тай; Солонгосын Хойг, Өмнөд Хятадын тэнгисийн хямрал, худалдааны маргаан зэрэг асуудлаас үүдэлтэйгээр АНУ Хятадтай сэргэлдсөн, үл ойлголцсон байдал нь хоёр хөрштэй Монгол Улсын НАТО-тай харилцах харилцаанд зарим талаар сэргөөр нөлөөлөх магадлалтай.</p>

- НАТО-гийн хувьд түншлэлийн тусгай хөтөлбөрөөр¹ хамтран ажиллах;
- НАТО-гийн өндөр, дээд хэмжээний чуулга уулзалт, НАТО-гийн Парламентын Ассамблейн хуралдаануудад Монгол Улсын төлөөллийг оролцуулах;
- улс төр, олон улс болон бус нутгийн аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар зөвлөлдөх уулзалт хийх, НАТО-гийн төрөл мэргэжлийн бага хурал, сургалт, семинарт хамрагдах боломж нээгдсэн;
- Батлан хамгаалах боловсролыг хөгжүүлэх “DEEP” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь стратегийн түвшинд удирдлагын чадавхыг нэмэгдүүлж, батлан хамгаалахын боловсролын удирдлага, төлөвлөлтийг сайжруулах, багшах бүрэлдэхүүний чадавхыг хөгжүүлэх;
- НАТО-тай харилцсанаар монгол цэргийн хэргийн мэдлэг дадлага чадвар, цэрэг-эх оронч хүмүүжил дээшилж, нийгмийн асуудлаа цэргийн алба хаагчид өөрсдөө тодорхой хэмжээгээр шийдвэрлэх боломж нээгдсэн;
- Монгол Улс Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн;
- Мянганы сорилтын сан Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүдээс санхүүжилт орж ирэх нь нэмэгдсэн гэх зэрэг давуу талыг бий болгосон.

Боломж:

- Дээд, дунд хэмжээний хурал, чуулга уулзалтад оролцож, НАТО-гийн тэргүүлсэн цэргийн ажиллагааны талаарх бодлого, сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл, өгч буй үнэлэлт, дүгнэлттэй танилцах, чиг хандлагыг тандаж судлах;
- НАТО-гийн ажиллагаанд оролцож буй бусад орны бодлого, байр суурь, цаашдын оролцооны талаарх мэдээллийг авах;
- НАТО-гийн гишүүн болон түнш орнуудтай адил түвшинд яриа хэлэлцээ хийх, тэдгээртэй улс төр, эдийн засаг,

Аюул занал:

НАТО-гийн тэргүүлсэн Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй “Шийдэмгий шийдвэр” ОУ-ын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн бие бүрэлдэхүүн аюулгүй байдлын эрсдэлийн өндөр түвшинд үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цагийн байдлын хувьд тухайн улс орны улс төрийн тогтвортгүй байдал, шашны хэт даврах зэвсэгт бүлэглэлүүдийн хоорондох мөргөлдөөн идэвхжих үед аюулгүй байдал хурцдаж, халдлага дайралтад өртөх магадлал ихэсдэг нь

¹ Англи хэлнээ Individual Partnership Cooperation program буюу IPCP гэж НАТО-д нэрлэгдэж тогтсон.

<p>эрдэм шинжилгээ, судалгаа, цэргийн чиглэлээр харилцаагаа өргөжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - НАТО-гийн иргэний болон цэргийн мэргэжлийн чиглэлийн сургалт, сургууль болон бусад арга хэмжээнд оролцох боломж нээгдэх, оролцсоноор манай алба хаагчид өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, бусад орны зэвсэгт хүчинтэй хамtran ажиллах дадал суух, арга барилаас нь суралцах, харилцан ажиллах чадварыг нэмэгдүүлэх; - Монгол Улсын төрийн байгууллагуудад шаардлагатай чиглэлээр төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хамtran хэрэгжүүлэх боломж нээгдэх; - НАТО-гийн гишүүн болон түнш орнуудад Монгол Улсаас олон улс, бус нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах үйл хэрэгт оруулж буй хувь нэмэр, өөрийн Зэвсэгт хүчиний оролцоог таниулах, байр сууриа илэрхийлэх; - Монгол Улсын “гуравдагч” хөршийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиг тусаа өгөх - НАТО-гийн “Аюулгүй байдал, энхийн төлөө шинжлэх ухаан” хөтөлбөрийн хүрээнд “Кибер аюулгүй байдлын төв байгуулах. 	<p>бие бүрэлдэхүүний амь насанд аюул учруулах магадлалыг өндөрсгөдөг.</p>
---	---

4.1.4. Гадаад орчны шинжилгээ /улсын хэмжээнд/

Орчны хүчин зүйл	Үзүүлэх нөлөөлөл
Улс төр	<p>НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд оролцох, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлснээр Монгол Улсын гадаад таатай орчныг бүрдүүлэх, гадаадын зээл, тусlamжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэх, хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, бус нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд эергээр нөлөөлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - улс төрийн үйл ажиллагаа батлан хамгаалах, зэвсэгт хүчиний хөгжилд нөлөөлнэ.
Эдийн засаг	<ul style="list-style-type: none"> - Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсвөөс болон хуульд заасан эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа нь батлан хамгаалах, зэвсэгт хүчиний хөгжилд нөлөөлнэ. - Улс орны эдийн засгийн боломж, чадавхаас батлан хамгаалахын хөрөнгө оруулалт, зардлын хэмжээ шууд хамаарна. - Батлан хамгаалахын улсын төсвийн хувь, хөрөнгө оруулалтын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхгүй нөхцөлд

	<p>хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ.</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах стратегийн ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчнийг оролцуулснаар улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. - Батлан хамгаалахын эрдэм судлал, цэргийн зэвсэглэл, техник, технологийн шинэчлэл нь өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инновац шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих урт хугацааны бодлогод нийцэж, төрөөс батлан хамгаалах үзүүлэх эдийн засгийн хөрөнгө оруулалт, төсвийн эзлэх хувь, хэмжээ өснэ. - Инженерийн боловсрол бүхий цэргийн дээд мэргэжилтэй алба хаагчид, Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд уул уурхай, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарт бүтээн байгуулалтын ажилд оролцох нь эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
Нийгэм соёл	<ul style="list-style-type: none"> - Нийгэм соёлд үзүүлэх нөлөөлөл нь урт хугацааны байх бөгөөд хүн ам зүйн байдал, эдийн засаг, нийгмийн хөгжлөөс шууд хамаарна. - Хүн амын эрүүл мэнд, боловсрол, амьдралын чанар нь Зэвсэгт хүчнийг мэргэжлийн, чадварлаг бүрэлдэхүүнээр хангах хүний нөөцийн бодлого, зорилтод шууд нөлөөлнө. - Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, хариуцлагыг хөндөхгүй. - хүүхэд залуучуудын эх оронч хүмүүжил төлөвшилд ахиц гарч, тэдний бие бялдар, сэтгэл зүй, хандлагад эерэг өөрчлөлт бий болно. - иргэдийн эх оронч хүмүүжил, түүх, уламжлал, төрийн цэргийн байгууллагуудыг хүндлэх, Үндсэн хуулиар тогтоосон үндсэн болон журамт үүргийг хэрэгжүүлэх ойлголт, хандлага дээшилнэ. - цэргийн нэгтгэл, анги, байгууллага үйл ажиллагаа явуулж буй орон нутагт ажлын байр нэмэгдэж, анги, байгууллагуудын спорт, соёл урлаг, сургалтын байгууламж нь орон нутгийн иргэдийн төрийн үйлчилгээ авах, амралт, соёлыг түгээх, төр, иргэний харилцан ажиллагаа нэмэгдэх нөхцөл болно.
Технологи	<ul style="list-style-type: none"> - Цэргийн шинжлэх ухаан, технологи, цэргийн зэвсэглэл, техник, технологийн шинэчлэл нь улс оронд өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр тодорхойлогдож, инновац шингэсэн шинэ нэр төрлийн цэргийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд нөлөөлнө. - Технологийн хурдацтай хувьсал, гаднаас хараат байдал нь зэвсэглэл, техникийн шинэчлэлийн эрчимд нөлөөлнө.
Хууль эрх зүй	<p>Хууль эрх зүйн орчны нөлөөлөл нь батлагдан гарсан хууль эрх зүйн баримт бичгүүдэд батлан хамгаалах эрх ашгийг хэрхэн тусгаснаас шууд хамаарна.</p> <p>Батлан хамгаалахын багц хуулийн шинэчлэлт, бодлогын тогтвортой байдал нь батлан хамгаалах хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.</p>

	<p>Улс орноо батлан хамгаалахад дараах хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг голлон мөрдөж байна:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль; - Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал; - Гадаад бодлогын үзэл баримтлал; - Алсын хараа-2050; - Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс; - Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль; - Зэвсэгт хүчний тухай хууль - Цэргийн албаны тухай хууль - Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль - Дайны байдлын тухай хууль - Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хууль - Дайчилгааны тухай хууль - Орон нутгийн хамгаалалтын тухай хууль - Төрийн албаны тухай хууль - Төсвийн тухай хууль
Байгаль орчин	<ul style="list-style-type: none"> - Монгол орны байгаль орчин, уур амьсгал батлан хамгаалах, зэвсэгт хүчний үйл ажиллагаанд төдийлөн нөлөөлөхгүй. - Зэвсэглэл, цэргийн техникийн хадгалалт, хамгаалалтад уур амьсгалын нөхцөл тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

4.1.5. Дотоод орчны шинжилгээ

Дотоод орчны шинжилгээг хийхдээ байгууллагын тогтолцоо, нөөц (хүн, санхүү, мэдээллийн технологи) зэрэг хүчин зүйлсийн хүрээнд тодорхойллоо.

Орчны хүчин зүйл	Үзүүлэх нөлөөлөл
Байгууллагын тогтолцоо	<p>Стратеги төлөвлөгөөг одоо байгаа байгууллагын тогтолцоогоор хэрэгжүүлэх боломжтой.</p> <p>Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг бүтцийг бүрдүүлж, бэхжүүлэх шаардлагын хүрээнд захиргааны үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулалтын бүтэц, нэгжүүдийн чиг үүрэгт хязгаарлагдмал хүрээнд өөрчлөлт хийгдэнэ.</p> <p>2020 онд Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулсан нь тус тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх, шинээр цэргийн анги, төвүүд байгуулах шаардлага үүснэ.</p> <p>Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад аливаа нэгэн байгууллагыг татан буулгах шаардлага үүсэхгүй.</p>
Хүний нөөц	<p>Жил бүр дотоод, гадаадын их, дээд сургууль, дамжааг 1500-2000 офицер, ахлагч төгсөж байна.</p> <p>Батлан хамгаалах яам, харьяа байгууллагын хүний нөөцийн хангалт 86 орчим хувь бол ЗХЖШ, командлалууд, нэгтгэл, анги, салбарын хүний нөөцийн хангалт 75 орчим хувьтай байна.</p> <p>Хүний нөөцийн төлөвлөлтөд урт хугацаанд тодорхой өөрчлөлт орохгүй.</p>

	Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн бүрэлдэхүүний ангилал, албан тушаалын шаардлага, мэргэжил, мэргэшлийн шалгуур үзүүлэлтэд бага хэмжээний өөрчлөлт орно.
Санхүүгийн нөөц	Батлан хамгаалах улсын төсвийн хувь, хөрөнгө оруулалтын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхгүй нөхцөлд хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. Эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээнээс хамаарч батлан хамгаалах хөгжлийн өндөр төсөв, өртөг бүхий бодлогын төсөл, арга хэмжээ нь эргээд төр, засагт дарамт учруулж болзошгүй. Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн сул хөгжил нь батлан хамгаалахын хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сэргөөр нөлөөлж, төсвийн болон гадаад улсын техник, технологийн тусламж, хандиваас шууд хараат байдлыг нэмэгдүүлнэ.
Мэдээллийн технологийн нөөц	Төрөөс төрийн үйлчилгээг цахимжуулах, e-mongolia төслийг хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, мэдээллийн нууцын шаардлагад нөлөөлнэ. Батлан хамгаалах яамны дотоод мэдээлэл солилцох систем /Microsoft Exchange Server 2010/, дайчилгааны мэдээллийн сан, бичиг хэргийн бүртгэлийн систем, байгууллагын цахим архив, Cloud university оюутны цахим систем, Medsoft эмнэлгийн мэдээллийн систем, ВЕБ хуудсыг өнөөгийн байдлаар сүлжээнд хэрэглэж байна. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх шаардлага үүснэ.

4.1.6. Орчны шинжилгээний үр дүн

Гадаад ба дотоод орчны зүгээс нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсны үндсэн дээр орчны шинжилгээний үр дүнг СВОТ (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) хүснэгтэд дараах байдлаар нэгтгэн харууллаа.

Орчны шинжилгээний үр дүн

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
<p>Стратеги төлөвлөгөөг одоо байгаа байгууллагын тогтолцоогоор хэрэгжүүлэх боломжтой.</p> <p>2020 онд Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулсан нь бүтцийн өөрчлөлтийг дахин хийхгүй.</p> <p>Жил бүр дотоод, гадаадын их, дээд сургууль, дамжааг 1500-2000 офицер, ахлагч төгсөж байна.</p> <p>Батлан хамгаалах яам, харьяа байгууллагын хүний нөөцийн хангалт 86 орчим хувь бол ЗХЖШ, командлалууд, нэгтгэл, анги, салбарын хүний нөөцийн хангалт 75 орчим хувьтай байна.</p>	<p>Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулснаар тус бүтцийг бэхжүүлэх, хөгжүүлэх, шинээр цэргийн анги, төвүүд байгуулах шаардлага үүснэ.</p> <p>Эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээнээс хамаарч цэргийн хөгжлийн өндөр төсөв, өртөг бүхий бодлогын төсөл, арга хэмжээ нь эргээд төр, засагт дарамт учруулж болзошгүй.</p> <p>Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн сул хөгжил нь батлан хамгаалах хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сэргөөр нөлөөлж, төсвийн болон гадаад</p>

